

# Asaya

**МИНИ УГААЛГЫН МАШИН (ЭВХЭГДДЭГ ТӨРӨЛ)  
ГАРЫН АВЛАГА**



**ЗАГВАР: ABWWG20NP0WBL**

Asaya брэндийн холигчийг сонгосонд баярлалаа.

Гарын авлагыг хэрэглэгч та бүхэнд бүтээгдэхүүнийг зөв, бүрэн гүйцэд ашиглахад туслах үүднээс бэлтгэв.

Уг бүтээгдэхүүнийг ашиглахын өмнө гарын авлагатай танилцана уу!

Хэрэглэгчийн гарын авлагатай танилцсаны дараа бүтээгдэхүүний гэмтэл засвар болон гарч болзошгүй гэмтлийг засварлах үүднээс гарын авлагыг хадгална уу!

Бусдад дамжуулахаар бол гарын авлагыг хамтад нь өгнө үү!

### **АЮУЛГҮЙН САНАМЖ**

- Бензин, будаг, идэмхий бодис, хүчиллэг суурьтай химийн бодисоор бохирдсон хувцасыг угаалгын машинд угааж болохгүй.
- Суурилуулахдаа 220V хүчдэлийг ашиглана уу
- Угаалгын машиныг угаалгын өрөө гэх мэт хэт чийглэг орчинд хадгалж болохгүй
- Угаалгын машиныг 5 °C доош температуртай орчинд бүү байршуулж эсвэл ашиглаарай.
- Тохиромжтой ариутгах угаалгын бодис сонгоно уу. Халдваргүйжүүлэх угаалгын бодис хэрэглэхдээ бодисыг нүдэндээ оруулахаас сэргийлнэ үү. Хэрэв таны нүдэнд орвол шууд усаар угаана уу.
- Залгуурыг хуурай алчуураар тогтмол арчина уу (хуримтлагдсан тоос, чийг гэх мэт).
- Хүүхдийн эргэн тойронд хэрэглэхдээ болгоомжтой байгаарай.
- Ус гоожилт үүсэж болзошгүй тул ашиглалтын явцад машиныг бүхэлд нь хазайлгаж, хөдөлгөж болохгүй.
- Нойтон гараар цахилгааны залгуурт хүрч болохгүй. Утсыг нь татаж залгуурыг бүү салга.
- Угаалгын машины ойролцоо бензин болон бусад шатамхай хий, шингэнийг бүү хадгал.
- Угаалгын машины доод хэсгийн үндсэн хэсэгт ус цацаж болохгүй, энэ нь цахилгааны гэмтэлд хүргэж болзошгүй.
- Угаалгын машинд 60°C-аас дээш температуртай усыг шууд хийж болохгүй, бүтээгдэхүүн өндөр температураас болж хэв гажилт, муудахаас сэргийлнэ үү.
- Угаалгаа дуусгаад дараа нь унтрааж байгаарай. Программыг шууд ажиллуулахгүйгээр унтрааж болохгүй, энэ нь цахилгаан хэрэгсэлд гэмтэл учруулах болно.
- Хэвийн бус байдал, доголдол илэрвэл хэрэглэхээ нэн даруй зогсоож, цахилгааны залгуурыг салгаж, унтраана уу.
- Энэхүү гарын авлагад заагаагүй бол угаалгын машины эд ангиудыг засварлаж, сольж болохгүй. Хэрэв цахилгааны утас гэмтсэн бол аюулаас зайлсхийхийн тулд үүнийг үйлдвэрлэгчийн мэргэжлийн хүн, засварчинп хандана уу.

## 2. ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ЗАГВАР	ABWWG20NP0WBL
Хүчин чадал	180 Вт
Багтаамж	2 кг
Дуу чимээ	≤60дБ
Давтамж	50 Гц
Хүчдэл	220 В
Бүтээгдэхүүний хэмжээ	360x360x380 мм
Эвхсэний дараах хэмжээ	360x360x185 мм

## 3. СУУРИЛУУЛАХ АЛХАМУУД

Эвхэгддэг угаалгын машиныг зөв холбохгүй бол машин хэвийн ажиллаж чадахгүй. Усны оролт, гаралт, цахилгааны холболт нь доорх стандартын дагуу байх ёстой.

### Бараа хүлээн авахдаа шалгах

Бүтээгдэхүүний хайрцаг, сав баглаа боодлын уутыг авна уу. Иж бүрдэлүүд бүрэн байгаа эсэхийг шалгана уу.

### Суурилуулах байршил

Бүтээгдэхүүний гадна өнгө хувирхаас сэргийлж халуун дулаан, нарны гэрлээс хол байрлуулна.

Угаалгын машиныг тэгш газар байрлуулна уу.

### Бохир усаа асгах

1. Доогуур ус асгах: Тавцан дээрх хаалтыг сугалж авснаар машин өөрөө усыг зайлуулж эхэлнэ. Ус шавхагдсаны дараа таглааг буцаан хийнэ.
2. Дээгүүр ус асгах: Усыг хурдан гадагшлуулахын тулд гар аргаар шууд дээгүүр усыг асгаж болно. Эхлээд унтрааж, бүтээгдэхүүн болон цахилгааныг салга. Бариул болон сүүрийн нүхийг бариад, усаа асгана.

Доогуур ус асгах нь удаан хугацаа их ордог тул яарч байгаа үед шууд дээгүүр асгахыг зөвлөж байна.

Тэмдэглэл: Мини эвхэгддэг угаалгын машин нь жижиг тул ус зайлуулах хоолойн диаметр нь том биш. Ус удаан зайлуулагдах нь хэвийн үзэгдэл тул тэвчээртэй хүлээнэ үү.

### Усны Оролт

Угаалгын машины саванд шууд цэвэр ус хийнэ, хамгийн дээд түвшин "Н"-г давуулж болохгүй.

### Цахилгааны холболт

Цахилгааны хүчдэл нь бүтээгдэхүүн дээрх мэдээллийн самбартай тохирох ёстой.

Угаалгын машины холболтыг салгахдаа дараах алхмуудыг дагана уу.

1. Цахилгаан болон залгуурыг салга
2. Саван дахь усыг зайлуулна
3. Угаалгын машиныг арчиж, цэвэрхэн байлгана

#### 4. ЭД АНГИЙН ТАНИЛЦУУЛГА



#### **Угаалгын Бодис**

Угаалгын бодисыг сонгохдоо хөөс багатай эсвэл хөөсгүй бодис, саван хэрэглэхийг зөвлөж байна.


Угаалгын бодисыг хийх арга: Угаалгын бодисоо шууд угаалгын саванд хийнэ.

#### **Угаалгын багтаамж**

Хувцас угаах: 1.8 кг-аас бага жинтэй; дотуур хувцас, оймс гэх мэтийг угаахад зориулагдсан.

Хувцсаа гараараа гаргаж мушгиж, хатаагч машинд хийнэ үү.


## 5. ЦАХИЛГААНЫ БҮДҮҮВЧ ДИАГРАМ



## 6. ХЭРЭГЛЭЭ


### УГААЛГЫН МАШИНЫГ ДЭЛГЭХ

Эхлээд тагийг нь авч, дараа нь нэг гараараа бариулыг өргөж савны ёроолыг нөгөө гараараа дарна (хэлбэрээ алдаж магадгүй тул хувцас эргүүлэгчийг битгий дар).



1. Тагийг нь ав;
2. Бариулыг нэг бариулаар өргөх;
3. Хувингийн ёроолыг нөгөө гараараа барьж, бариулыг дээш нь татах;
4. Эвхдэг хувинг бүрэн тэлснээр бэлэн болно.

### УГААЛГЫН МАШИНЫГ ЭВХЭХ



1. Хувингийн тагийг ав
2. Угаалгын машины дээд хүрээг хоёр гараараа дарж доош нь чиглүүл
3. Эвхдэг хувингаа аажмаар эвхэж, хувинг тагла

### **Хувцсаа угаалгын машинд хийхийн өмнө**

Ус зайлуулах хоолойг бөглөж, угаалгын машины гүйцэтгэлд нөлөөлөхгүйн тулд хувцасны дотор болон гадна талд наалдсан шороо, гадны биет гэх мэтийг урьдчилан арилгаж хувцсаа угаалгын машинд хийнэ.

### **Угаалгын машинд хувцас хийх**

Үр дүнтэй угаалга хийхийн тулд хувцсаа дэлгэж, угаалгын хувинд хийнэ үү;

### **Угаалгын бодис нэмэх**

Угаалгын саванд тохирсон хэмжээний угаалгын бодис хийнэ.

#### **Анхаар:**

- Машиныг зэврүүлэхгүйн тулд хүчтэй хүчил эсвэл хүчтэй шүлтлэг угаалгын бодис хэрэглэж болохгүй.
- Угаах явцад ус зайлуулах хоолойг бөглөхгүйн тулд усанд амархан уусдаг угаалгын нунтаг хэрэглээрэй.
- Угаах явцад хэт их хөөсрөн угаах явцанд нөлөөлөхгүйн тулд хөөс багатай эсвэл хөөсөрдөггүй угаалгын бодис сонгоорой.

## **7. ТОХИРГОО**

Угаалгын машиныг 15 минут ажиллах горимд тохируул. Угаалгын хэмжээнээс болон бохирдлын зэргээс шалтгаалан нэг буюу хэд хэдэн программыг ашиглаж болно.

Угаах программыг сонгоод, угаах цагны бариулыг "15" тоо руу эргүүлэхэд автоматаар ажиллаж эхэлнэ. Цэвэрхэн болоогүй бол хоёр дахь удаагаа программыг сонгож өгнө. Цагны бариулыг "15" байрлал руу эргүүлнэ. Машин автоматаар ажиллаж эхэлнэ

#### **Анхаар!**

Угааж дууссан бол цахилгаан хангамжаас салгана үү. Цахилгаан хангамжийг урьдчилан таслах нь цахилгаан хэрэгслийн гол бүрэлдэхүүн хэсгүүдэд гэмтэл учруулах болно.

## **8. УГААЛГЫН МАШИНЫ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ**

1. Хувцсаа угаалгын саванд хийж, зохих хэмжээний угаалгын бодис хийнэ.
2. Хувцсыг бүхэлд нь норгохын тулд бага зэрэг ус хийнэ (3-5 см хувцаснаас илүү).
3. Таглааг савны дээр тавиад, угаагчийн таймерыг асаагаад "15мин" дээр тавина. Машин автоматаар ажиллаж эхлэх болно.
4. Угааж дууссаны дараа цаг автоматаар дахин тохируулагдан машин зогсоно.
5. Угаалгын машинаас хувцсаа гаргаж авна.
6. Машины цахилгааны шугам болон залгуурыг салгана.
7. Угаалгын машинаас ус зайлуулна.
8. Машиныг арчина.

## 9. ЦЭВЭРЛЭГЭЭ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

Угаалгын Дараа усны чанарт өөрчлөлт оруулахгүйн тулд угааж дууссан бол угаалгын машин дотор байгаа бүх усыг асгана уу.

Машиныг арчиж, угаалгын машиныг эвхэж, таглана уу.

## 10.АЛДААГ ЗАСВАРЛАХ

Хэрэв та машиныг эвдэрсэн байж магадгүй хэмээн эргэлзэж байвал дараах жагсаалтыг эхлээд хараарай.

Хэрэв асуудал шийдэгдэхгүй бол үйлчилгээний ажилтан, мэргэжлийн засварчинтай холбогдоно уу.

Угаалгын машинд өөрөө засвар хийж болохгүй!

Асуудал	Байж болох шалтгаан	Шийдэл
Ус асгасаны дараа ус үлдсэн байна	Усыг бүрэн шавхаагүй	Хуурай болтол нь арчих
Дээрээс нь ус асгарч байна	Усны түвшин хэт өндөр байна	Усыг багасгах
Машин ажиллахаа больсон	Цахилгаан тасарсан Эрчим хүчний хоорондох холбоо мүү эсвэл залгуур суларсан. Цагийн тохиргоог хийгээгүй.	Цахилгаан тасарсан эсэхийг шалгах Залгуурыг сайтар шалгах Цагийн тохиргоог хийнэ үү
Хувцас нь эргэлдээгүй	Хувцас хэтэрхий хүнд байна. Хүчдэл хэтэрхий бага байна	Хувцасны хэмжээг багасгах Хүчдэл хэвийн үед хэрэглэх

### Хэрэглээнээс гарсан хуучин цахилгаан бараа хаягдал, устгал

Цахилгаан болон электрон тоног төхөөрөмжийн хог хаягдал (Waste Electrical and Electronic Equipment 'WEEE') 2002/96/EC -ын Европ дахь удирдлагууд дараах байдлыг тодорхойлсон байна.

Хуучин цахилгаан барааны хог хаягдлыг энгийн хог хаягдалтай хольж хаяж болохгүй бөгөөд энэ нь байгаль орчны болон хүрээлэн буй орчин, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн нэг учир эдгээр хохирлыг багасгахын тулд хуучин цахилгаан барааны хог хаягдлыг хотын хог хаягдлаас ялгаж тусад нь устгалд оруулж байх мөн хуучин цахилгаан барааны эд ангиуд дахин ашиглагдах материалд ордог тул тусад нь ялгаж ашиглаж болох хэсгүүдийг дахин ашиглах боломжтой гэж үзнэ.



Энэхүү тэмдэглэгээ нь таны худалдан авсан ахуйн хэрэгцээний цахилгаан болон электрон бараа дээр байвал уг барааг хаях үедээ тусад нь ялгаж байх гэсэн тэмдэг юм.

Худалдан авагч хуучин цахилгаан бараа болон электрон бараа тэдгээрийн хог хаягдлыг хэрхэн хаана устгалд оруулж болох дахин ашиглах, эс ашиглах зэргийг орон нутгийн захиргаа болон Нэкт Дистрибьюшн ХХК – ийн засвар үйлчилгээний төвөөс авч болно. Монгол улсын хэмжээнд хуучин хэрэглээнээс гарсан цахилгаан барааг устгах тухай, хаана хэрхэн хаях талаар тодорхой мэдээлэл хараахан гараагүй ч манай Нэкт Дистрибьюшн ХХК нь удахгүй энэ асуудлыг шийдвэрлэх гарцыг олж хэрэглэгч үйлчлүүлэгч танд мэдээлэл хүргэх болно. Бидний амьдралын өлгий болсон байгаль орчноо хамгаалахад хүн бүхний оролцоо хамгаас чухал билээ.

**Нэкт Дистрибьюшн ХХК – ийн Засвар үйлчилгээний төвийн хаяг: Нэкт Сервис Засварын төв, Ард Аюуш өргөн чөлөө, Баянгол дүүрэг-13, Улаанбаатар хот, Монгол улс.**